

ЕРТӨНЦИЙН ХЭЛМЭЛ ДҮР ЗУРАГЛАЛ ТҮҮНИЙ ГЕРМЕНЕВТИК ТАЙЛБАРЛАЛ

Б.Пүрэвсүрэн /магистр/ ШУТИС.ХУС.

Түлхүүр үг: Ертөнц, хэлний дүр зураглал, ертөнцийн шинжлэх ухааны дүр зураглал, коннотаци, концепт, хэлний соёл

М.Хайдеггер
“хэл бол ахуйн сууц мөн”

Энэ дэлхий ертөнц дээр амьдарч байсан болон амьдарч буй хэн бүхэн үе үеийн туршид хорвоо ертөнцийн талаарх өөрийн дүр төсөөлөл буюу зураглалыг өөртөө бичсээр, бүр дахин давтан засварласаар өнөөг хүрсэн билээ.

Аливаа бичигдсэн зүйл буюу мэдээг бид ертөнцийг үзэх үзэл, үзэл суртал, шинжлэх ухаан, шашин домгийн гэх мэтээр нэрийдсээр ирсэн ажгуу. Эдгээр зураглалаас эдүгээ бид шинжлэх ухааны зураглалыг үнэнд хамгийн ойр бодит зураглал хэмээн үздэг ч уг зураглал мөн л сонгодог, сонгодог бус, сонгодог бусын дараахь зураглал¹¹⁷ хэмээн үечилсэн байдаг.

Ертөнцийн талаарх шинжлэх ухааны дүр зураглалын бүтэц нь байнга сэлбэгдэж байдаг онолын төв цөм, суурь үндэслэлүүд, онолын загваруудаас тогтдог. Онолын төв цөм нь харьцангуй тогтвортой шинжийг хадгалж, удаан хугацаанд оршин тогтносноор ертөнцийн талаарх зураглал үүсэх боломжийг бүрдүүлдэг. Энэ цөм шинжлэх ухааны тухайн төрөл бүрдээ тогтмол шинж бүхий онтологи чанартай байснаар өөр өөрсдийн зураглалуудыг бүрдүүлнэ. Энэ чанараараа ертөнцийн талаарх хэлний дүр зураглал хэлний онтологи агуулгын хүрээндээ үүсэх боломж бүрдэнэ.

Хэл бүхэн зарчмын хувьд ертөнцийг зураглах өөрсдийн онцлогтой байдаг ч энд хэлний тэмдэглэн бичих болон ертөнцийг хүртэн мэдрэх зэргийг онцлов.

Хэлний философийн гол төлөөлөгч Л.Витгенштейний “Логик-философийн шаштир” бүтээл “1.1. Ертөнц гэдэг бол юмс бус, харин баримтуудын цогц юм” гэж эхэлдэг бол тухайн баримт нь угтаа хэлний бодит агуулгыг илэрхийлсэн хэлний нэгжүүд байдаг. Хэдийгээр түүний “Философийн судалгаа” хэмээх дараагийн гол бүтээл өмнөхөөсөө нилээд ялгаатай ч хэлний бүтцийг үндэсний менталь бүтэцтэй агуулгаар нь адилтган буулгах гэсэн нь хэлний загварчлал, зураглалын томоохон санаа зорилгыг агуулжээ гэж үзэж болно. Эдүгээ энэ уламжлал нь хэллэгийн логик болон хиймэл оюун, тархины загварчлалын судалгаатай олон талаараа холбогдох өв болж илрэв.

Хэл бол ертөнцийн талаарх хүний мэдлэгийг дүрслэх, томъёолох, мэдээлэх, хадгалах нэн чухал арга хэрэгсэл бөгөөд ертөнцийн талаарх хүний төсөөлөлийг судлах явцад хэлээр дамжин бүрэлдэн буй болсон үзэгдлийг ертөнцийн талаарх зураглал, хэлмэл зураглал хэмээн нэрлэх болсон. Харин түүнийгээ ертөнцийн хэлмэл зураглал, ертөнцийн хэлмэл загвар, ертөнцийг хэлээр төлөөлөхүй, хэл дундын ертөнц гэх зэргээр нэрлэсэн ажгуу.

Гэхдээ бодит байдлын тусгал болсон ертөнцийн зураглал, энэхүү тусгалын бичиглэл болох ертөнцийн хэлмэл зураглалын хооронд үлэмж нийлмэл харилцаа оршдог. Ертөнцийн зураглалыг орон зай /хол ойр, дээр доор, баруун

¹¹⁷ Шинжлэх ухааны философи Орч. А.Энхбаатар УБ., 2006 он. х.58-71, В.П.Кохановский и др. Философия для аспирантов Рос-на-Дону 2003.г стр. 186-98

зүүн, өрнө дорно/, цаг хугацаа /өдөр шөнө, өвөл зун/, ёс суртахууны болон бусад параметрээр илэрхийлэх боломж той.

Ертөнцийн аливаа зураглалд хэл, уламжлал, байгаль, ландшафт, сургалт хүмүүжил болон бусад социаль үзэгдэл хүчин зүйл нөлөөлнө. Тухайлбал эдүгээ манай оронд төдийлөн яригдахгүй байгаа хэлний ландшафтын асуудал ч хэлмэл зураглалтай нягт холбоотой болохыг зарим нэгэн жишээгээр харуулж болох юм. Судлаач Б.Сумъяа гуайн /“Монголын нүүдэлчдийн соёл” УБ.,2006. х.121/ бүтээлд яагаад монголчууд асар хүчтэй эргэлдэн эрчилсэн шороон шуургыг угалз гэж нэрлэдэг юм бэ? хэмээн асуугаад түүнийгээ тайлбарласан байдал нь ертөнцийн монгол дүр зурагийг гаргах явцдаа ашигласан жишээ боловч энэхүү өгүүллийг бичигчийн хувьд говь хээрийн бүсэд оршин амьдрагч хүмүүсийн ахуйгаас гарсан хэлний бүтээгдэхүүн буюу говийн ландшафттай холбоотой үг хэмээн тайлбарлах саналтай байна. Улмаар амьтны төрөл зүйл болох угалз, гоёл чимэглэлийн урлаг дахь хээ хуарын төрөл болох угалз нь бүгд л угалз хэмээх дүр дүрслэлтэй давхцаж байна. Гэхдээ асуудлын гол зөвхөн үүндээ бус харин ертөнцийн монгол дүрд хамаарах орчлон хэмээх үгийн язгуур утгатай холбоотойгоор асуудлыг дэвшүүлсэн нь сонирхолтой юм.

Ертөнцийн хэлмэл зураглалын онцлогыг харуулахын тулд зарим нэгэн тайлбарыг хийх хэрэгтэй болдог. Энэ зураглал нь ертөнцийн тусгаар зураглалуудтай /физик, хими/ адилгүй бөгөөд хэлний тусламжтайгаар өөрөө өөрийгөө болон ертөнцийг ойлгох чадамж дээр буюу хүн төрөлхтөн, үндэстэн, нийгэм-түүхийн туршлага дээр нэгтгэгдэн буй болох хурмал зураглал юм.

Өөрөөр хэлбэл түүхэн ухамсар нь ертөнцийг үзэх үзэл болон хэлмэл зураглал үүсэх нөхцлийг хангаж өгнө. Энэ тухай Ю.Д.Апресан үзэхдээ “ертөнцийн хэлмэл зураглал нь бодит байдлын объектив мэдлэгийг агуулсан зураглал байх ёстой. Жишээ нь: атом, цэг, гэрэл, дулаан г.м. Гэтэл эдгээр үгсийн утгыг судалбал түүний когнитив /сэтгэлгээний/ загварын онцлог шинж бүхий ертөнцийн эгэл зураглалт чанарыг илрүүлж болно.

Ийм учраас хүн ертөнцийг танин мэдэхдээ алдаа төөрөгдлөөс ангид бус байж, түүний ертөнцийн концептуаль зураглалыг байнга бодож, “сэтгэлдээ зурж”, урт удаан хугацааны туршид уг алдаагаа дотроо хадгалж байдаг”. Жишээ нь теоцентрист сэтгэлгээний хэв маяг болон ертөнц хавтгай гэж үзэх үзэл. Монголын нэгэн уран сайхны кинонд дэлхийн бөмбөрцгийн үзүүлбэр загварыг өшиглөж буй лам банди “Чи бөөрөнхий гэлүү, чамайг ингээд хавтгай болгоод өгье” хэмээн хэмхчих нь ертөнцийн зураглал хир зөрүүтэй байгааг уран сайхны хэлбэрээр харуулдаг.

Мөн хэлмэл зураглалд тухайн ард түмний сэтгэл хөдлөлийн илрэл тусгалаа олох ёстой. Соёл судлалын болон хэлний шинжлэлийн нэр томъёог хэрэглэвэл ертөнцийн болон хэлний зураглал нь хэлний семантикийн кодчилал юм.

Улмаар энэ зураглал нь хэлний семантик систем, идэвхитэй менталь загвар, хэлний коллектив шинж зэргээс урган гарч хүний ертөнцтэй харилцах хэв маяг, түүнийг хуран мэдрэх, зохион байгуулах арга барил болдог. Өөрөөр хэлбэл хэлний нэн тэргүүний үүрэгт мэдээлэл дамжуулах, харилцахаас гадна дотоод зохион байгуулалтын үүрэг багтдаг. А.Н.Леонтьевийн хэрэглэсэн нэр томъёогоор бол “орон зайд утга холбогдох” зохион байгуулалт болно.

Энэ бүгдээс үзвэл ертөнцийн хэлмэл зураглал нь түүний талаарх мэдлэгийн иж бүрдэл, цаашилбал үгсийн сан, хэлц үг зэргээр тодорхойлогдоно. Энэ бол хэлний структурализмд холбогдох ертөнцийн хэлний зураглалын бүтцийн тайлбар болно.

Ертөнцийн хэлмэл зураглалд холбогдох зарим онол, үзэл баримтлалтай одоо танилцъя. **Л.Вайсгерберийн үзэл баримтлал:** Энэ нь В.Гумбольдтын “хэлний дотоод хэлбэр”-н тухай хэл шинжлэлийн онол үзэл баримтлал буюу хэлний

агуулгад угсаатны шинж онцлог хэрхэн тусгагдах тухай үзэл санааг харуулдаг. Тэрээр "Төрөлх хэл, сэтгэлгээ ба үйлдлийн хоорондын холбоо" /1930/ "төрөлх хэл өөртөө ертөнцийн тодорхой зураглал бүхий ойлголтуудаа агуулж байснаараа хэлний нийтлэгүүдийн гишүүнчлэлээ бүрдүүлдэг" /стр.250/ гэсэн бол "Төрөлх хэл ба оюуны төлөвшил" /1927/ бүтээлдээ "хүн бүхий л туршлагыг багтаасан ертөнцийн нэгэн зураглал бүхий хэлийг ашигладаг" /стр.151/ гэсэн ба энэ нь хүрээлэн буй орчин ертөнцийг хуран мэдэрсэн хэл байдаг гэж үзсэн нь угтаа хэлмэл зураглал төдийгүй хэлний ландшафтын судалгааны онолын үндэс болсон гэж үзүүштэй байна. Үүнийгээ Л.Вайсбергер "Соёлын системд хэлний эзлэх байр суурь" /1934/ бүтээлдээ бүр тодорхой тусгасан байх ба ертөнцийн хэлмэл зураглалын бодит биет гол үндэслэлүүд бол байгаль, тэр дундаа хөрс, газарзүйн нөхцөл, цаг уур, амьтан ургамалын ертөнц болно" /стр.251/ гэж үзсэн байдаг.

Хэлний гештальтуудын онол: Гол төлөөлөгч нь Дж.Лакофф болон неогумбольдтистууд. Гештальт бол хэлний өвөрмөц гүн агуулгын нэгж ажээ. Өөрөөр хэлбэл хүн бодит байдлыг хуран мэдрэх үндсийг хэлэн дэхь гештальтууд бүрдүүлж, түүнийгээ хэлнээ харуулдаг байна. Хэлний гештальтын гүн шинж нь хэлэнд харьцангуйгаар хэд хэдэн хандлагаар илэрнэ. Нилээд дээд түвшиндээ бол мэргэжлийн хэллэгийн эрэл хайгуулын шинжээр илэрнэ хэмээн Дж.Лакофф үзжээ. Цаашилбал гештальтыг ерөнхийдөө хүний психик байдлын гүнд орших, хэлний гадуурх категориаль хүрээнд орших универсаль төсөөлөл гэж тайлбарласан байх ба хэлний бодит өгөгдөлд үндэслэсэн реконструкцилал болж байна. Энэ нь жам ёсоороо үүсэж хөгжсөн бодит ахуйд суурилсан хэл гэдэг бол соёлын семантик бүтэц бүрдэлтэй бөгөөд тэр л бүтэц загварынхаа дагуу биеждэг ажээ.

Энэ үзэл нь орчин үед неогумбольдтизмтай төрөл үзэл санаа болсон байна. Уг үзэл баримтлалаар бол ард түмэн бүр өөр өөрийнхөөрөө ертөнцийн олон янз байдлыг дүрээр дүрслэн реконструкчлал хийдэг. Энэ нь хувь хүн, бүлэг нийтлэг, үндэстэн угсаатан бүрийн вербаль болон вербаль бус туршлага дээр үндэслэгдсэн гэсэн үг юм.

Неогумбольдтистуудынхаар бол ертөнцийн хэлмэл зураглалын үндэсний дүрслэлийг түүхийн урт удаан хугацааны хөгжлийн үр дүн гэж үзэлгүй хэлний өөрийнх нь шинж онцлогт хамааруулдаг.

Тэдний үзлээр хүмүүс хэлний тусламжтайгаар өөр өөрийнхөө ертөнцийг бүтээж, түүгээрээ ч бие биеэсээ ялгарч, өөрийгөө хүрээлүүлдэг. Ертөнцийн зураглалын тухай яриа өрнөлөө гэхэд түүний талаарх шинжлэх ухааны төсөөлөл, үзэгдэл, юмс, шинжийн об'ектив дүрслэл нь бус харин об'ектив ертөнцийн суб'ектив дүр л нэн тэргүүнд үүссэн байдаг. Гэвч хэл өөрөө дангаараа энэхүү суб'ектив ертөнцийн зураглалыг үүсгэхгүй. Энд л ертөнцийн хэлмэл болон шинжлэх ухааны зураглалын ялгаа оршино.

Үүний цаана хувь хүний болон нийгмийн ухамсар оршин байдаг. Хэл нь өөрөө энэ тохиолдолд танин мэдэхүйн үйл явцын шаардлагыг биелүүлэгч болдог. Ертөнцийн хэлмэл зураглалд хамаарах нэгэн зураглал бол концептуаль /үзэлжсэн/ зураглал юм. Хүмүүс хэдийгээр олон янзын хэлээр ярьдаг ч гэсэн энэ зураглалын нөхцөлд ойрхон байх боломжтой байдаг. Үүнийг эх хэлний онцлогоор тайлбарлаж болно.

Ертөнцийн зураглалын нэг онцлог бол дан ганц об'ектив бус суб'ектив байр суурь шингэсэн байдаг тухай өмнө өгүүлсэн билээ.

Иймд энэ зураглал бол их идэвхитэй, тасралтгүй зураглал болохыг харуулж байна.

Үүнээс үзвэл ертөнцийн хэлмэл зураглал нь социаль хэв маягийн байр суурь, хандлага, харилцаа, үнэлгээ, үндэсний хэлний системд тэмдэгтээр дүрслэн

тусгасан байгуулал болж байна. Энэ нь хэлмэл зураглал гэдэг бол үндэсний болоод төрөлх эх хэлэнд суурилдаг болохыг цохон тэмдэглэж буй хэрэг юм.

Өөрөөр хэлбэл ертөнцийн хэлний зураглал ерөнхийдөө ертөнцийн логик тусгал хүний ухамсарт туссан байдлаараа давхцдаг болохыг хэлц үгний орчуулгуудаар батлан харуулж болно. Энэ нь ертөнцийн хэлмэл зураглалыг бүтээхэд хэлц үг буюу фразеологи онцгой үүрэгтэй болохыг харуулдаг. Үүнийг заримдаа тухайн “үндэстний амьдралын толь” хэмээнэ.

Хүнийг дүрсэлсэн үг, хэлцээс зарим нэгэн жишээг авч үзье. Жишээ нь: Толгой.

Хэдийгээр энэ биеийн дээд хэсэг хэмээн биеийн анатомийн хувьд үзэх боловч хэлэхүйн билэгдлийн хувьд оюун ухааны төв, интеллект шинж, дээд үнэ цэнэ хэмээх соёлын семантик утга агуулгыг шингээсэн байна.

Цаашилбал хэлний антропологийн хувьд авч үзвэл “толгойтой хүн”, “алтан толгой” гэх хэллэг нь зөвхөн интеллигент хүнийг төдийгүй эрэгтэй интеллигент хүнийг илэрхийлсэн байх нь олонтой. Учир нь славян болон энэтхэг-европын язгуурын ихэнхи хэлэнд хүн гэдэг үг зөвхөн эрэгтэй хүн гэдгээр илэрхийлэгдсэн байдгаас үзвэл хүний ертөнцийн талаарх хэлмэл зураглал гэдэг бол эрэгтэй хүний ертөнцийн талаарх зураглал гэдэгтэй аналог буюу агаар нэгэн томъёолол болно.

Хэл шинжлэлийн харьцангуйн онол: Гол төлөөлөгч нь Э.Сепир, Б.Л.Уорф нар юм. Ертөнцийн юмс үзэгдэл харьцангуй /релятив/ болох тухай үзэл болон ертөнцийн зураглал хэмээх нэр томъёо нь XIX зууны сүүл үе болох М.Планк, А.Эйнштейн нарын нарын физикчдын үзэл баримтлалаас эхлэлтэй. Энэ нь хэл, соёлын шүтэлцээний асуудлыг өнгөрсөн зууны эхээр гаргаж тавьсан америкийн этнолингвистикуудын онол үзэл баримтлал юм.

Үүнийг хамтатган эдүгээ Сепир-Уорфын хэл шинжлэлийн харьцангуйн таамаглал хэмээн нэршжээ. Америкийн этнолингвистик, соёлын антропологич Ф.Боас, түүний шавь Э.Сепир болон Б.Уорф нар энэ үзлийг хөгжүүлсэн байна. Тэдний үзлээр хэлний дүрэм харьцангуй бөгөөд хэл үзэгдлийн төрлүүдийг илэрхийлдэг. Гэтэл үзэгдэл бүхэн өөрөө харьцангуй шинжтэй. Эцэст нь тэд хэлний ангилал гэдэг бол үнэхээр бодитой орших тодорхой соёлын хүрээнд бүрэлдсэн универсаль концептуаль орон зайн ангилал юм хэмээжээ. Үүнээс үзвэл хэлний ялгаа гэдэг бол угтаа зөвхөн этносийн ялгаа болох нь тодорхой байна. Нөгөө талаас соёлын ялгаа гэдэг бол нэн тэргүүнд этносоор буюу хэлний ялгаанд л илэрдэг гэсэн үг юм. Энэ тухай К.Леви-Стросс “хэл бол соёлын цаг үеийнх нь бүтээгдэхүүн, түүний чухал бүрэлдэхүүн хэсэг ба соёлын орших нөхцөл. Чухамдаа хэл нь соёлын код төлөвших хүчин зүйл, соёлын орших өвөрмөц арга¹¹⁸” хэмээжээ. Үүнээс үзвэл ертөнцийн хэлмэл зураглал нь соёлын орчин нөхцөлд үндэслэгдэн кодоор бүтээгдсэн зураглал болж байна.

Хэл шинжлэлийн герменевтик болон герменевтик философийн хувьд ертөнцийн хамгийн нэгдмэл буюу интеграль, универсаль зураглал гэгддэг философийг өөрийн ахуйн биелэл болсон хэл, зөвхөн түүнээс л урган гарсан соёлын үзэгдэл гэж үздэг. Энэ утгаар философи гэдэг бол ойлголтуудын түүх байдаг тухай олонтой өгүүлсэн билээ. Герменевтикийн хувьд бол хэл, ойлгохуйн харьцааны асуудал, хэлний түүхэн талбар дахь утга тайлал буюу интерпретац хийх урлаг, нөхцөл, арга зүйг голлон анхаарсан байдаг¹¹⁹.

Энд А.Пуанкарегаас эхлэлтэй хэлний конвенционалист үзэл бас хамаарах бөгөөд Э.Сепирын үзсэнээр хэл бол өөрийг нь бүрдүүлэгч аваи болон дүрэм, үгсийн сангийн хоорондох шаталсан чанд зохион байгуулалттай систем болохыг онцолдог зэрэг нь энэхүү релятив үзлийн үндэс болдог.

¹¹⁸ В.А.Маслова “Лингвокультурология” М.,2001, стр.62

¹¹⁹ Б.Пүрэвсүрэн “Хэл ойлгохуйн харьцааны асуудлыг герменевтикийн үүднээс тайлбарлах нь” // Эрх чөлөө ба философи УБ.,2001. № VIII х.46-54


Герменевтик: Гол төлөөлөгч Ф.Шлейермахер, Х.Г.Гадамер болон амьдралын философийн зарим төлөөлөгчид багтана. Герменевтикийн хувьд хэлний ойлгохуйн асуудалд гол анхаарлаа хандуулдаг ба “ойлгохуй хэлний орчинд үүсдэг учир цоо шинээр буй болдог бус харин хэлний орчинд үүссэн сэтгэлгээний үргэлжлэл байдаг”¹²⁰ хэмээн үзнэ. Улмаар ойлгохуйн үйл явцтай холбоотойгоор үүссэн хэлний асуудал өөрөө герменевтикийн судлагдахуун болон хувирдаг. Хамгийн сонирхолтой нь ойлгохуй эдүгээ шинжлэх ухааны бүхий л мэдлэгийн салбарт хамааралтай байгааг /хамгийн чанд мэдлэгийн салбарт хүртэл/ өгүүлж болохын зэрэгцээ хэлний гештальттай холбоотой байж болох сэтгэлзүйч Ж.Брунерын “аяндаа танин мэдэхэд бэрхшээлтэй зүйл гэж үгүй. Гагцхүү агуулгыг илэрхийлэхэд тохирох хэл олдтол хүлээх хэрэгтэй болно”¹²¹ гэж хэлснийг цохон тэмдэглэе.

Ертөнцийн хэлмэл зураглалтай холбоотойгоор хэл ойлгохуйн асуудлыг авч үзвэл хэлний хувьд оногдохууны шинж чанартай, ойлгохуй нь онохуйн чиг хандлагатай байх ба хэл ойлгохуйн хүрээндээ оногдохуун болж, тайлбарлахуйн хүрээндээ хэрэгсэл болж байна. /Б.П/

Ертөнцийн хэлмэл зураглал өөрөө зохиогч болон тексттэй холбоотой учраас ертөнцийн талаарх зохиогчийн хэлмэл зураглал уншигчийнхтай давхцаж болох эсэх тухай герменевтикийн үндсэн асуудал энд мөн л урган гарч ирнэ. Нэгэн чигт утгаараа ойлгохуйн давхцал шууд үүсэхгүй ба энэ текстэнд бодит байдал болон зохиогчийн үзэл санааг бүрэн дүүрэн тусган илэрхийлж чадахгүй гэж үзэх арга зүйтэй холбоотой байдаг.

Энэ талаар Х.Г.Гадамер “хэл бол хүн ертөнц хоёрыг нэгтгэн холбогч бөгөөд ойлгохуйн оногдохуун болж байдаг ахуй бол хэл юм. Угтаа хүн, ертөнцийн харилцаа хэлний хүчин зүйлсээр нөхцөлдсөн байдаг тул ойлгох боломжтой байдаг”¹²² гэж үзсэн. Энэ бүгдээс үндэслэн ертөнцийн зураглал, ертөнцийн хэлний болон шинжлэх ухааны зураглалыг Буриадын УИС-ийн доктор И.Ж.Степанагийн боловсруулсан схем загварыг толилуулснаар энэхүү хэсгийг өндөрлөө.

Схем 1 Ангилал 1: Ертөнцийн зураглалыг байршлаар нь дүрсэлсэн байдал




Схем 2

¹²⁰ Понимание // Философской энциклопедической словарь М., 1989 г.

¹²¹ Д.Баттөмөр “Танин мэдэхүйн уг чанар ба механизм” // Эрх чөлөө ба философи УБ., 1998. № 1. х. 8.

¹²² Х.Г.Гадамер “Истина и метод: Основы философской герменевтики” пер.с.нем. М., 1988. Стр.448-150,


Ангилал 2: Ертөнцийн зураглалыг шинжлэх ухаанч шинжээр нь ангиласан байдал




Схем 3

Схем 4

Ангилал 4: Ердийн болон уран сайхны шинжээр ангилах





Энэ бүх зураглалуудаас үзвэл ертөнцийн хамгийн өргөн зураглал бол концептуаль зураглал байх бөгөөд тэр нь мэдлэгийн бүхий л төрөл салбар, сэтгэлгээний төрөл бүрийн хэв маягуудыг өөртөө багтаасан зураглал ажээ. Дараагийн тохиолдолд бүс нутгийн болон үндэсний, хүн амын тодорхой бүлэг нийтлэгийн ертөнцийн талаарх зураглал, эцэст хувь хүн бүрийн ертөнцийг үзэх үзэл өөрийнх нь томъёололоор бий болно. Түүнээс гадна шинжлэх ухаанч шинжийн үүднээс бол шинжлэхүйн салбар бүрээр зураглалууд үүсэж байна.

Монголчуудын ертөнцийн хэлмэл дүр зураглал: Ертөнцийн хэлмэл зураглалыг бид хэлнээс эхтэй гэж чиглэл зааж буйч биосферис улбаатай ноосфер, семиосфер, цаашилбал концептосфер зэрэг нэр томъёог түлхүү ашиглах хэрэгтэй болж байна. Монгол хэл дэлхийн үндэстэн угсаатны бусад хэлүүдийн нэгэн адил монгол хэмээх этносийг бүрдүүлэн төлөвшүүлж нэгтгэж байгаа хамгийн чухал юугаарч сольшгүй үнэт зүйлс мөнөөс мөн билээ. Хэлний гол үүргийг ч Гумбольдт, Леви-Стросс нараас эхлэлтэй байж болох этносийг нэгтгэх буюу монгол этносийг монгол хэлний нэгэн дээвэр дор нэгтгэн буй интеграль-универсаль үүргээр тайлбарлавал зохистой юм.

Ертөнцийн талаарх монгол хэлний зураглалыг байгуулах ертөнцийн гурвал, ертөнцийн үүсэл хөгжлийн талаарх монгол домог үлгэр, зүйр болон цэцэн үгс, хэлц болон сургааль үгс, ардын аман болон уран сайхны бүтээлүүд цогц байдлаараа бүрэлдэн тогтсон нь дамжиггүй юм. Ертөнцийн хэлмэл зураглалд хэл бичгийн дүрэм өөрийн зохих байр суурьтайг тэмдэглэх нь илүүц байж болох ч "үйл нь ирсэн хүн үсгийн дүрмээр оролдоно, үхэл нь ирсэн хулгана муурын сүүлээр оролдоно" гэсэн хэлцийг буй болгосон өөрөө бас хэлмэл зураглал юм. Ер нь хэлмэл зураглалд хэлц үгийн эзлэх байр илүүтэй тухай өгүүлсэн билээ.

Эдүгээ бид "ертөнц" хэмээх үг болон утгад шууд болон дам хамаарах олон үгсийг ашиглаж байдаг ба үүнд орчлон, сансар, хорвоо, огторгуй, дэлхий, эрхэс, замбуулин, тив, сав шим ертөнц багтана. Үүнээс ертөнцийн монгол дүр зураглалд хамаарах нэгэн тайлбарлалыг судлаач Б.Сумъяа гуайн тайлбарласнаар авч үзье.

Монголчууд нэн эрт цагаас ертөнцийн оршин тогтнох гол хэлбэр бол /уг нь материйн орших арга бол хөдөлгөөн гэдэг/ нь эргэлдэх хөдөлгөөн мөн гэдгийн таньж мэдсэнийг хэлний баримтаар нотолж болно гээд "Орчлон" хэмээх монгол үгийн язгуурыг хөөн үзвэл энэ үг санскрит, төвд, түрэг, уйгур, аль нь ч биш, цэвэр монгол гаралтай үг гэдгийг Монгол үгсийн язгуурын толиас олоод мэдчихэж болно. Энэ үгийн язгуур нь "орчи-" нь "эгэ-", "эргэ-" гэдэг язгууртай

нэгэн адил эргэх, эгэх, эрчлэх, эргэлдэх гэсэн утга заадаг гэж хэл бичгийн эрдэмтэд нотолсон байх юм. Тэр ч байтугай ээрүүл, ээрэнцэг, эрхэс гэх мэт монгол үг цөм л орчих, эргэх гэсэн утга заадаг. “Монголын нууц товчоон”-д “Одтой тэнгэр орчиж” гэж гардагийг хэн бүхэн мэднэ¹²³ гэх зэргээр учирлан тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл ертөнцийн монгол дүр зураглалд “орчлон” гэдэг үг чухал байр суурьтай ажээ. Цаашилбал хорвоо ертөнц хоймсон үүтгэл, гурамсан бүтэцтэй болох, гурван тив, гурван цаг, гурамсан хэмжигдэхүүнтэйг тэмдэглээд бусад судлаачдын “хас” бол “хаос” гэсэн үг мөн гэх мэт санааг онцлон дурьджээ.

Тэгвэл ертөнцийн монгол дүр зураглалд хөх өнгө нэн чухал байр суурьтай болохыг миний бие нэгэн өгүүлэлдээ тусган харуулахыг хичээж цаашдаа монголын уламжлалт соёлын судалгаанд “хөхийн урсгал” хэмээх нэр томъёололыг хэрэглэх, тэнгэризм буюу тэнгэр шүтлэг үнэхээр монголчуудын хувьд даяарчлалын оюун санааны үзэгдэл байсан гэж үзвэл хөх өнгө өөрөө глобаль буюу даяарчлалын өнгө байх төдийгүй монголын уламжлалт соёлын хувьд хөхийн урсгал /Mongolian blue wave/ буюу давалгаа, соёлын флуктуаци /лугшилт/ байдлаар бөөгийн буюу хөх мөнх тэнгэр шүтлэгээс эхлэлтэйгээр байнга хадгалагдсаар ирж “шарын аюул” гэгчээс зайлхийсээр ирсэн болно. Иймд монголын бөөгийн шүтлэг бол угтаа “хөхийн шүтлэг” байсан¹²⁴ тухай санааг өгүүлсэн болно.

Үүнээс гадна монголын анхны сансрын нисгэгчийн дурсамж ярианаас “дэлхий бол хамгийн үзэсгэлэнтэй гариг бөгөөд “Уяхан замбуутив” гэдэг бол хамгийн оносон гайхамшигтай нэр юм. Сансарт нисэж үзсэн хүн л энэ үгний утгыг илүү гүн мэдрэх байх” хэмээн ярьж байсныг энд тэмдэглэх нь зүйтэй болов уу. Мэдээж энэ нь ертөнцийн монгол зураглалд уртын дууны тэр дундаа “Уяхан замбуутивийн наран” дууны утга агуулгыг онцолж буй хэрэг.

Хөх мөнх тэнгэр шүтлэгийн тухай өмнө өгүүлсэн тул ертөнц хоосон чанартай тухай нэгэн дүрслэлийг авч үзье. Барин тавин зүүд хоосон, барзааж харагдах зэрэглээ хоосон, бархирч хашгирах цуурай хоосон гэсэн нь монголчуудын шашин-гүн ухааны зураглалд ертөнц хоосон чанартай тухай төв үзэл буюу мадхьяамака сургаалийн уламжлал юм. Уг сургаалийн гол цөм болох үгүйсгэлийн санааг эрдэмтэн Ш.Лувсанвандан хэл шинжлэлийн онолын судалгаандаа “үгийн сан эвдрэхийн хамт бүтнэ, бүтэхийн хамт эвдэрнэ” хэмээн шүтэн барилдалгааны томъёоллоор ашигласан байна.

Эцэст нь монголчуудын ертөнцийн хэлмэл зураглалд монгол хэлний үгсийн сангийн бичвэрийн нэгэн судалгааны үр дүнг авч үзье. Доктор Ц.Ганбатын судалснаар¹²⁵ /2003.01.01-ний байдлаар/ монгол хэлний нийт 94800 үгэнд хийсэн судалгаагаар хамгийн олон буюу 16802 үг /18%/ “х” үсгээр, 12496 үг /13%/ “т” үсгээр, 9587 үг /10%/ “б” үсгээр эхэлж ертөнцийн хэлмэл дүр зураглалыг монгол хэлнээ байгуулахад өөрийн “хувь нэмэр”-ээ оруулжээ. Түүнчлэн судалгаанд хамрагдсан нийт үгсийн 60% эр, 40% эм хүйсийн монгол үгс байсан нь монгол хэлний хүн судлалын судалгааны үүднээс авч үзвэл мөн л монгол хэлний үгсийн сангийн судалгаанд эр хүйс давамгайлж байгаа бусад хэлний нэгэн адил харуулж байна.

Мэдлэг бол хүч гэдэгтэй нэгэн адил үг бол хүч байдаг тухай монголчууд үгээр хүнийг үхүүлж ч болон, үгээр хүнийг амьдруулж ч болно гэдэг бол ертөнцийг

¹²³ Б.Сумъяа “Ертөнцийн монгол дүр зураг” // Монголын нүүдэлчдийн соёл УБ.,2006. .119дэх тал

¹²⁴ Б.Пүрэвсүрэн “Монголын уламжлалт нийтийн соёл дахь <<хөхийн урсгал>>” //Соёл судлаач багш нарын үндэсний V семинарын материал. УБ.,2007.05.12. х.61-63

¹²⁵ Ц.Ганбат “Монгол хэлний бичвэр боловсруулах зарим асуудал” /программ хангамж/ Докторын Ph.D зэрэг горилсон диссертаци. УБ.,2003 он. х.43-44

амьтнаар төлөөлүүлсэн дөрвөн хүчтэний дүрслэл ч бас нэн элбэг байдгийг нурун тайлбарлах шаардлагагүй биз ээ. .

Дүгнэлт

Ертөнцийн талаарх хэлний зураглал буюу ертөнцийн хэлмэл зураглал гэдэг бол эцсийн дүндээ үндэсний менталитетийн бүтээгдэхүүн, түүний нэн хурмал зураглал юм.

Ертөнцийн хэлмэл зураглалыг бүтээхэд зүйр болон цэцэн үг, ертөнцийн эр эм гэх хоймсон үүтгэл бүхий соёлын семантик өв, ертөнцийн гурвал, домог үлгэр, ардын аман соёлын өв, хэлц үгс оролцох боловч эдгээрийн дундаас хэлц үгний эзлэх байр суурь бусдаасаа өндөр байдаг гэж үзэж болох юм.

Хэл бол соёлын эрх чөлөөний биелэл учраас түүний хүлээсэнд үл баригдаж, соёлын шоконд эс орох, ертөнц дэхь чөлөөт байдлыг хэлээр дамжуулан мэдрэх, зураглах боломжийг олж авснаар хүний хэлний мөн чанар, түүний онтологи агуулгыг ухаарах боломж бүрдэнэ..

Ертөнцийн талаарх хэлмэл зураглалын гол элемент бол түүний концептууд болж байна. Хэлний үүргийг угсаатны хэл шинжлэлийн үүднээс болон түүний дотоод хэлбэрийн үүднээс этносийг нэгтгэгч гэж үзэх зохимжтой учраас монгол хэл монгол этносийн хурмал зураглал болж байна.

Талархал: Энэхүү өгүүллийг бичихэд үнэтэй зөвөлгөө өгсөн Доктор /Ph.D/ А.Энхбаатар, өөрийн судалгааны бүтээлээсээ илгээсэн Буриадын УИС-ийн доктор И.Ж.Степана нарт баярласнаа илэрхийлье.

Ашигласан ном зохиол

1. Д.Баттөмөр "Танин мэдэхүйн уг чанар ба механизм" // Эрх чөлөө ба философи УБ.,1998. № 1
2. Л.Витгенштейн "Логико-философской трактат" М.,1991.
3. Х.Г.Гадамер "Истина и метод: Основы философской герменевтики" пер.с.нем. М.,1988.
4. Г.Г.Гадамер "Актуальность прекрасного" пер.с.нем. М.,1991. г.
5. Ц.Ганбат "Монгол хэлний бичвэр боловсруулах зарим асуудал" /программ хангамж/ Докторын Ph.D зэрэг горилсон диссертаци. УБ.,2003 он.
6. Вильгельм фон Гумбольдт "Избранные труды по языкознанию" М.,1984 г.
7. Д.Дагвадорж "Буддын гүн ухаан, монгол уламжлал" УБ.,2003 он
8. "Шинжлэх ухааны философи" Орч. А.Энхбаатар УБ.,2006 он.
9. В..П.Кохановский и др "Философия для аспирантов" Рос-на-Дону 2003.г
10. В.А.Маслова "Лингвокультурология" М.,2001
11. В.А.Михайлов "Языки культуры" М.,1997. г.
12. Б.Пүрэвсүрэн "Хэл ойлгохуйн харьцааны асуудлыг герменевтикийн үүднээс тайлбарлах нь" // Эрх чөлөө ба философи УБ.,2001. № VIII
13. Б.Пүрэвсүрэн "Монголын уламжлалт нийтийн соёл дахь <<хөхийн урсгал>> " //Соёл судлаач багш нарын үндэсний V семинарын материал. УБ.,2007.05.12. х.61-63
14. Философской энциклопедической словарь М.,1989 г.
15. П.Рикёр "Конфликт интерпретации: Очерки о герменевтике" пер.с.фр. М.,1995 Б.Сумъяа "Ертөнцийн монгол дүр зураг"// "Монголын нүүдэлчдийн соёл" УБ.,2006. х.114-127

16. Э.Равдан "Хэл, соёлын шүтэлцээний тухай" //Гадаад хэл заах арга зүйн асуудал УБ.,2002. №1, 2
17. А.А.Реформатский "Введение в языковедение" М.,1999.г.
18. "Энциклопедия русский язык" М.,2003. г. Зав.ред. Т.А.Ганиева
19. "Словарь иностранных слов" М.,1980 г.

Ашигласан веб хуудас:

<http://www.lib-online.ru/index.php3?wid=34206&tid2=133&tid=131&rel=-1> /

<http://tutor.adviserjournal.com/?page=1809> /